



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 573

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 65,000,000.00 /жаран таван сая/ төгрөгийн балансын үнэ, 56,333,333.16 /тавин зургаан сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг арван зургаан мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, түүний оронд гэрээгээр хүлээн авсан “Газ Вепрь-330811” маркийн 130,000,000.00 (нэг зуун гучин сая) төгрөгийн балансын үнэтэй тусгай зориулалтын автомашиныг Орхон аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга Бригадын генерал Г.Ариунбуян, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын дарга хурандаа Б.Анхбаяр, Орхон аймгийн Онцгой байдлын газрын дарга хурандаа Г.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах,

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2020 оны... дугаар сарын ...-ны өдрийн

573 дугаар тогтоолын хавсралт



**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА СҮХБААТАР АЙМГИЙН ОНЦГОЙ  
БАЙДЛЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ТӨРИЙН ӨМЧИЙН ДАНС БҮРТГЭЛЭЭС  
ХАСАХ АВТОМАШИН**

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар                              | Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он | Балансын үнэ (төгрөг)                  | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)                                                                                       |
|-----|------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|----------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Камаз-5320 Цистерн, Улсын дугаар 93-68УНД, Арлын дугаар 0029693088, хөдөлгүүрийн дугаар 347810 | 1988/2015                          | 65,000,000.00                          | 56,333,333.16                                                                                                        |
|     |                                                                                                |                                    | 65,000,000.00 (Жаран таван сая төгрөг) | 56,333,333.16 (Тавин зургаан сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг арван зургаан мөнгө) |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ОРХОН АЙМГИЙН ОНЦГОЙ  
БАЙДЛЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ АВТОМАШИН**

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар                          | Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он | Балансын үнэ (төгрөг)       |
|-----|--------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|-----------------------------|
| 1   | ГАЗ Вепрь-330811 тусгай зориулалтын, Улсын дугаар 86-66ОРА, Арлын дугаар Х96330811G0000221 | 2017/2015                          | 130,000,000.00              |
|     |                                                                                            |                                    | (Нэг зуун гучин сая төгрөг) |